

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна

Тариачин
болон үр



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: M. Maillot; Lazarus

Найруулсан: E. Frischbutter; Sarah S.

Орчуулсан: Damdin Norolsuren

Alastair Paterson

Бүтээсэн: Bible for Children

www.M1914.org

©2020 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Нэгэн өдөр Есүс нуурын
эрэг дээр зогсоод сургаж
эхлэв. Олон хүн түүнийг
сонсохоор цугларсан**

**байлаа. Хурсан олон
дэндүү их байв. Есүс
ях ёстой вэ?**



**Ойролцоо байсан завин дээр Есүс гарч
зогсов. Одоо Тэр хүмүүсийн царайг
харж мөн хүмүүс ч Түүнийг
харах боломжтой болов.**



**Есүс хүмүүст сургаалт зүйрлэлээр
энгийн зүйлээр жишээ аван
Бурханы талаар тайлбарлав.**



**"Тариачин газартаа үр суулгажээ"
гэхэд Есүсийн үг нь зураг мэт
дүрслэгдэж байв.**




**Хүмүүс тариачин үр суулгаж
байгаагаар төсөөлөв.**



**Зарим үр зам дээр
унав. Яанаа! Тэднийг
шувууд ирээд идчихэв.**




**Зарим үр нь чулуурхаг хөрсөнд унав.
Хөрс нь гүн биш тул тэр дороо соёолов.
Гэвч нар гарахад үндэсгүй учир тэд
хорчийн хатжээ.**




**Зарим нь өргөс халгайн
дунд унав. Тэд үр ургуулж
чадсангүй. Учир өргөс халгай
ургаад тэднийг ус нарны
гэрлээс халхалчхав.**




Зарим нь сайн хөрсөнд унав. Цаг нь болж тэд ургацаа өгөхөд арвин их ургац гарав. Тариачин маш баяр хөөртэй байлаа.



Түүнийг ийнхүү сургасны дараа шавь нар нь Есүс уруу ирэв. Тэд "Та яагаад энэ сургаалт зүйрлэлийг ярьсан юм бэ?" гэж асуув.



Есүс энэ зүйрлэл хүмүүс Бурханы тухай тэд Түүнийг үнэхээр хайрладаг уу гэдгээ ойлгоход нь туслах болно гэлээ.



Есүс ярьсан зүйрлэлээ тайлбарлав.
Тэр үр бол Бурханы үг юм. Зам дээр
унасан үр нь Бурханы үгийг сонссон ч


ойлгоогүй
хүмүүс юм.



**Сатан тэднийг Бурханы
үгээс холдуулдаг ажээ.**



**Зарим хүмүүс Бурханы үгийг хурдан
хүлээж авдаг. Тэд бол чулуурхаг хөрсөнд унасан
үр юм. Гэвч удалгүй тэднийг хэн нэгэн тохуурхах юм
уу Бурханыг хайрлахын тулд хэцүү
тэвчих хэрэг гарвал тэд
гунигладаг.**



Ийм хүмүүс Бурханын үгийг эхлээд баяртайгаар хүлээн авч Есүсийг дагадаг ч Бурханы үгийн дагуу байж чаддаггүй. Тэд Бурханыг дагахын тулд мөнгө төлөхийг хүсдэггүй хүмүүс юм. Тэд Бурханаас илүү найзуудыгаа дээгүүр үздэг нь ямар харамсалтай хэрэг вэ?



**Сургаалт
зүйрлэлийн өргөс
халгай нь дэлхийн
санаа зовнил бөгөөд
зарим хүмүүс
зөвхөн мөнгийг
л боддог ажээ.**



**Тэд мөнгө
хураахын тулд
үргэлж завгүй
амьдардаг бөгөөд
ЭНЭ нь тэдний
амьдралыг
Бурханаас
холдуулдаг
байна.**



**Харин сайн хөрсөнд унасан үр сайн үр жимс
ургуулах бөгөөд энэ нь Бурханы үг хүмүүсийн зүрх
сэтгэлд орж тэдний амьдралд гарсан өөрчлөлт юм.**



Хурсан олон тэндээс явахыг хүсэхгүй байв. Олон хүн Бурханыг дагаж Түүний тааллыг олохыг хүсэв. Есүсийн сургаалт зүйрлэл тэдэнд Бурханыг хэрхэн дагах талаар ойлгоход тус болжээ.



Тариачин болон үр

Бурханы үг Библиээс авсан түүх

Матай 13

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

